



Б И М А У  
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 12 сарын 26

№ 371

Улаанбаатар  
хот

Улсын үйлдвэрийн газар  
байгуулах тухай.

БИМАУ-ын Аж ахуйн нэгжийн тухай хуулийг үндэслэн  
Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргаанаас  
ТОГТООХ НЬ:

1. Улаанбаатар хотын эмийн санг учирцах контор  
Хотын эмийн баазыг татан буулгаж гүйцэтгэж байсан  
үүргийг нэгтгэж хотын хүн амыг эм, эмнэлгийн бараагаар  
хангах үүрэг бүхий "Эм хангамж" компани / УҮГ / -ийг  
байгуулсугай.

2. Найрамлын районд эмийн сангийн I төв /УҮГ/  
Сүхбаатарын районд эмийн сангийн II төв /УҮГ/ эмийн  
сангийн III төв /УҮГ/, Ажилчин районд эмийн сангийн IV  
төв /УҮГ/, Октябрь районд эмийн сангийн V төв /УҮГ/  
эмийн сангийн VI төв /УҮГ/, Налайх районд эмийн сан-  
гийн VII төв, /УҮГ/ Багануур районд эмийн сангийн VIII  
төв /УҮГ/ тус тус байгуулсугай.

3. "Эм хангамж" компани /УҮГ/, эмийн сангийн  
төв /УҮГ/-ийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-  
ГААН /ДАРГА

Л.ЭНЭБИШ

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА

Ц.БОЛДСАЙХАН.

Улаанбаатар хотын Ардын Хурлын  
Гүйцэтгэх захиргааны 1991 оны  
371 тоот тогтоолын I хавсралт.

**"ЭМ ХАНГАМЖ" КОМПАНИ /УУГ/- ҮН ДҮРЭМ.**

**Нэг. Нийтлэг зүйл**

1. "Эм хангамж" компани /УУГ/ нь нийслэлийн эрүүл мэндийн байгууллага болон хөдөлмөрчдийн хэрэгцээт төрөл бүрийн эм, эмнэлгийн бараа, эмийн бэлдмэлээр хангах асуудлыг эрхлэн харуцах бөгөөд аж ахуйн бие даасан үйл ажиллагааг улсын үйлдвэрийн газар мөн.

2. "Эм хангамж" компаний зорилго нь нийслэлийн эрүүл мэндийн байгууллагууд болон хүн амд зориулан эм, эмнэлгийн бараа, эмийн бэлдмэлийг бэлтгэн хангах эдийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэхэд оршино.

3. Компани нь хуулийн этгээдийн эрх эдлэх бөгөөд зохих журмаар зөвшөөрөгдсөн тэмдэг, албан бичгийн нүүр ба хуудастай байна.

4. Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа эмийн сан, эмийн сангийн төв зэрэг үйлдвэр үйлчлэгээний газруудыг мэргэжлийн удирдлагаар хангана.

5. "Эм хангамж" компанийг Сайгуулах, татан буулгах асуудлыг Хотын Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргаа шийдвэрлэнэ.

6. Компанийг байгуулахдаа аж ахуйн нэгжийн тухай хуулийн 3,39,40 дүгээр заалтыг үндэс болгоно. Татварын улсын байгууллагад бүртгүүлж зохих гэрчилгээ авсан өдрөөс эхлэн компани нь өөрийн үйл ажиллагааг явуулах эрхтэй болно.

7. "Эм хангамж" компаний байршил нь: Барилгачдын талбай, байшин № II, утасны дугаар 24504 болно.

**Хоёр. Компанийн эд хөрөнгө**

8. Компаний хөрөнгө нь үндсэн сан, эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад нөөцөөс бүрдэнэ. Үндсэн сан



эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр нь өөрийн болон эвэлийн хөрөнгө юм. Үндсэн сангийн элэгдлийн шимтгэл, үйлдвэрлэл шинжлэх ухаан, техникийг хөгжүүлэх, сангийн хөрөнгөөр үндсэн сангийнхаа нөхөн үйлдвэрлэл явуулна.

9. Компани нь эд хөрөнгөө иууль тогтоомжийн заалт болон өөрийн дүрэмдгээ нийцүүлэн үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах үндсэн дээр өмчлэх эрхтэй байна.

#### Турав. Компаний удирдлага.

10. Компаний өдөр тутмын ажлыг түүний захирал удирдана. Компаний захирлыг томилж болон уг ажлаас чөлөөлөх тухай асуудлыг Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргаа шийдвэрлэнэ.

#### II. Компаний захирал нь:

а/ Эрх хэмжээнийхээ дотор хууль тогтоомжийн заалт удирдах дээд байгууллагын тушаал зааварт нийцүүлэн тушаал, заавар гаргах

б/ Удирдах байгууллагын тушаал зааврыг үйл ажиллагааныхаа хүрээнд мөрдөх

в/ Байгууллагын нэрийн өмнөөс бусад байгууллага, ард иргэдтэй иүүд харилцах, хөдөлмөр, иргэний болон аж ахуйн нэгжийн тухай хуулийн заалтын дагуу гэрээ байгуулах, төлбөр тооцоо хийх, хамтын болон дагнасан үйлдвэрлэл үйлчлэгээ явуулах

12. Компаний захирал болон захиргааны гишүүд нь аж ахуйн бусад нэгжийн гишүүн, удирдлагын бүрэлдэхүүнд байхыг хориглоно. Харин хувьцаа эзэмшигч байхыг зөвшөөрнө.

#### дөрөв. Компаний үүрэг.

13. "Эм хангам" компани нь нийслэлийн дутаг дэвсгэрт байгаа эмнэлгийн байгууллага болон хөдөлмөрдөд эм, эмнэлгийн бараагаар үйлчлэх зорилгыг хэрэгжүүлэх ажлыг харууцаж эмийн чанар, эмчлэгээний үр ашгийг дээшлүүлэх, эмийг зохистой зарцуулах зэрэг бусад шинэ арга хэлбэрээр ажиллана.

14. Эмийн хэрэгцээ шаардлага болон түүнийг хараглах явдалд дүн шинжилгээ хийх, эм, эмнэлгийн барааны талаар

## 3.

зах зээлийг судлах, эмийн хэрэгцээ, унийн бодлого, эм эмнэлгийн бараг хэрэгсэлийн тухай дотоод, гадаад худалдаатай холбогдсон асуудлаар санал боловсруулах удирдах шатны мэргэжлийн байгууллагад тавьж хэрэгжүүлнэ.

15. Шинэ эм технологи, төхөөрөмж, шинжлэх ухааны мэдээлэл, эмийн зах зээлийн худалдааны асуудлаар эм зүйн мэдээллийн ажлыг эрхэлнэ.

16. Эмийн нөлөөний өөрөг үр дагавраас сэргийлэх, түүнийг зориулалтын дагуу үр ашигтай хэрэглэх болон эмийг мэргэжлийн хяналтгүй хэрэглэх зохиогүй зуршлын өөрөг хотын Эрүүл мэндийн байгууллага, эмч хөдөлмөрчдэд мэдээлэл, сурталчлагаа хийж ажлыг гүйцэтгэнэ.

17. Хотын хүн амын эрүүл мэндийг хамгаалах эм био бэлдмэл, уламжлалт монгол эм үйлдвэрлэх, худалдаалах асуудлаар хотын Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллана.

18. Төрийн байгууллагын өмнө хүлээх төшгийн даалгаврыг бүрэн биелүүлж дотоод үйл ажиллагаандаа хяналт шалгалт явуулна.

19. Эмнэлгийн байгууллага, хөдөлмөрчдийг гадаад орны болон эх орны эм, эмийн бэлдмэл, эмнэлгийн бараагаар хангах, эмийн хүрэлцээ, чанарыг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

20. Тус улсын хууль тогтоомжийн заалт, басгийн газрын шийдвэр, Эрүүл мэндийн яамны тухаал, зааврыг хэрэгжүүлнэ.

## Тав. Компаний эрх

21. Эрүүл мэндийн тухай хууль болон бусад хууль тогтоомжоор олгосон эрхийн хүрээнд эмийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх зохион байгуулалт эдийн засаг, техник технологийн дэвшилт арга хэмжээ авна.

22. Хүн амыг эмээр хангах, эмийг хадгалах зарцуулахтай холбогдсон асуудлаар нийслэл хотын дэвсгэрт байгаа улс, хоршооллын байгууллагуудтай хамтран ажиллаж шаардлагатай үед мэргэжлийн зөвлөлтөө өгч ажиллана.



3.

23. Өөрийн үйл ажиллагаанд холбогдсон асуудлаар БНМАУ-ын нутаг дэвсгэрт байгаа дотоод, гадаадын аж ахуйн нэгж, хувалда а, үйлдвэр, хангамжийн газартай харилцан гэрээ хэлэлцээр байгуулах, төлбөр, тосроо хийх, хамтын болон дагнасан үйлдвэрлэл, үйлчлэгээ зохион байгуулна.

Зургаа. Бусад зүйл.

24. Тус компани нь холбогдох банк, санхүү, статистикийн байгууллагад тогтоосон журмын дагуу мэдээ тайлангаа тогтмол үнэн зөв гарган мэдээлж байх зарчмыг баримтлан ажиллана.

25. Энэхүү дүрэм болон гэрээнд нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд цаг тухайд нь улсын бүртгэлийн байгууллагад зохих журмаар мэдэгдэнэ.

26. Компанийг БНМАУ-ын аж ахуйн нэгжийн хуулийн 5-р зүйлд заасан үндэслэлийг баримтлан Улаанбаатар хотын АХ-ын гүйцэтгэх захиргааны шийдвэрээр татан буулгана.



Улаанбаатар хотын Ардын Хурлын  
Гүйцэтгэх Зөвлөл 1991 оны  
ТООТ ТОГТООЛЫН II ХАВСРАЛТ.

**ЭМИЙН САНГИЙН ТӨВИЙН ДҮРЭМ /УУГ/**

**нэг. Нийтлэг зүйл**

1. Эмийн сангийн төв нь эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллага, хөдөлмөрчдийг эм, амнэлгийн бараанаар хангах ажлыг харьяалсан нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд эрхлэн явуулах эм зүй, эмчлэн сэргийлэх үйлчлэгээний аж ахуйн нэгж мөн.

2. Төвийн даргыг районы Ардын Хурлын Гүйцэтгэх Зөвлөлөөс захиргааны захиралжаар эмийн сангийн төвийн бусад ажилтныг төвийн даргын тушаалаар тус тус томилно.

3. Эм, эмнэлэг, ариун цэвэр, эрүүл мэндийн бараа түүхий эдийг гадаад, дотоодны үйлдвэр худалдааны байгууллагуудтай захиалга гэрээгээр бэлтгэн хэрэгцээнд нийлүүлнэ.

4. Төв нь оршин байгаа нутаг дэвсгэрийн хүн амын хэрэгцээг харгалзан Эмийн сан, эм, амнэлгийн барааны үйлдвэрлэл эрүүл мэндийн үйлчлэгээний цаг салбар байгуулж бүтэцээ тогтооно.

5. Төвийн үйл ажиллагааны тайланг хуанлийн I дүгээр сарын 31-нээс 12 дугаар сарын 31-нд дуусгал хугацаагаар тогтооно.

6. Төвийн үйл ажиллагааны энэ дүрмээр зохицуулагдахгүй бусад асуудлыг БИМАУ-ын аж ахуйн нэгжийн тухай хуулийн холбогдох заалтуудыг удирдлага болгон шийдвэрлэнэ.

**Хоёр. Төвийн үүрэг.**

7. Төв хөгжлийнхөө хэтийн чиглэлийг шинжлэх ухааны судалгаа улсын эрүүл мэндийн бодлого, нийгэм эдийн засгийн хүчин зүйлийг харгалзан ~~бэлтгэн~~ үйлдвэр зохиож мөрдөх.

8. Эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллага хүн амын эм, амнэлгийн барааны хэрэгцээг судалж захиалга үйлдэж үйлдвэр худалдаа, хангамжийн байгууллагуудтай ханган нийлүүлэлтийн аж ахуйн гэрээ



байгуулж татан авч түгээх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд эрхсэн хөтлөх

9. Эм зүйн дэглэм, эм найруулан бэлтгэх технологийн зааврын мөрдөлтийн хатуу хяналт тогтоон чанарын шаардлага хангасан эм бэлтгэж үйлчлэх, эмийн зүйл, эмийн түүхий эдийг өндөр үнээр дамлан худалдах, ашиг хонжоо олох зорилгоор хуурамч эм саригсадтай БНМАУ-ын хууль тогтоомжийн биелэлтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэхийн төлөө тэмцэл явуулах

10. Эмийн зохистой нөөцтэй байж Эмийн сангийн үйлчлэгээний хэвийн ажиллагааг хангах, эмийн нөлөөний сөрөг үр дагавраас сэргийлэх түүнийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах болон эмийг мэргэжлийн хяналтгүй хэрэглэх буруу зуршлын сөрөг дургийн эрүүл мэндийн байгууллага, эмч нартай хамтран хөдөлмөрчдөд мэдээлэл сурталчлагаа хийх ажлыг гүйцэтгэнэ.

11. Төр засгийн орон нутгийн эм хангамжийн байгууллагын өмнө хүлээсэн төсвийн даалгаврыг бүрэн биелүүлэх

12. Эмийн сангийн үйл ажиллагаагаар үүсэх эм зүй, санхүү эмчийн харилцаанд хяналт тогтоох

13. Ажил үйлчлэгээндээ шинжлэх ухаан техникийн амьлт дөвшилт технологи нэвтрүүлэх замаар үндсэн үзүүлэлтийг дээшлүүлж байх.

14. Эмийн хангамжийг намэгдүүлэх, материаллаг баазаа бэхжүүлэх, боловсон хүчин бэлтгэх асуудлыг дургийн болон дургийн нийгмийн хөгжлийн хөтөлбөрт туслах хэрэгжүүлэх.

Гурав. Төвийн эрх

15. Хуулийн этгээдийн эрх эдэлж албан бичгийн хуудас, тэмдэг хөрөглөнө.

16. Байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон эрхийг Төвийн дарга бусад албан тушаалтны ажил үүргийн хуваарьт тусгах хэрэгжүүлэх.

17. Өөрийн үйл ажиллагаанд холбогдсон асуудлаар дотоод гадаадын албан газар, худалдаа үйлдвэр хангамжийн байгууллагатай харилцаж гэрээ хэлэлцээр байгуулах төлбөр тооцоо хийх, хамтын болон дагнасан үйлдвэрлэл үйлчлэлгээ зохион байгуулах

18. Өөрийн үйл ажиллагаа ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар Шүүх арбитрийн байгууллагад нэхэмжлэх, харууцагчаар оролцох

19. Аж ахуйн гэрээ хэлэлцээр холбогдсон өмнөлөг урьдчилан сэргийлэх байгууллагын эм, эмнэлгийн барааны хангамж, хадгалалт зарцуулалтын байдлыг шалгах акт тогтоох, холбогдсон мэдээ судалгааг шавардаж гаргуулах.

20. Төв нь үйлчлэгээнийхээ сүлжээг тогтоож түүний ажилтнуудын орон тоо, цалингийн санг хууль тогтоомжийн дагуу баталж мөрдөх.

#### Дөрөв. Хөрөнгө

21. Төв нь үндсэн болон эргэлтийн хөрөнгө санхүүгийн нөөцөөр дүрмийн санг түсгэнэ. Дүрмийн сангийн хэмжээг балансад тусгана. Үндсэн ба эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр нь улсын хөрөнгө оруулалт, мөнгөн зээл байна. Үндсэн хөрөнгийн элэгдлийн их ээсвэрийн шимтгэлийн 90%-ийг Эмийн сангийн төв өөртөө хуримтлуулж үндсэн сангийнхаа нөхөн үйлдвэрлэл явуулна.

Төвийн эргэлтийн хөрөнгийн нийт хэмжээ /норматив/-г гаарын санал, дүүргийн санхүүгийн хэлтсийн зөвлөлийн үндсэн дээр өөрсдөө тогтооно.

22. Эмийн сангийн төв нь зохих фондуудтай байна.

Үүнд:

- а. Үйлдвэр үйлчлэлгээ хөгжүүлэх фонд
- б. Цалин хөдсний нэгдсэн фонд
- в/ Нийгмийн хөгжлийн фонд
- г. Тусгай фонд

Фондуудынхаа зохих хэсгийг удирдах дээд байгууллагад төвлөрүүлэн зарцуулж болно.



## 4.

## Тав. Удирдлага

23. Төвийн дарга удирдах бөгөөд түүнийг томилж чөлөөлж асуудлыг районы Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргаа шийдвэрлэнэ.

24. Эмийн сангийн төвийн дарга БНМАУ-ын ам ахуйн нэгжийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 5-д заасан эрхтэй ажиллаж орон нутгийн төвийн ажлын үр дүнг харуулна.

25. Дарга төвийн эд хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, тогтоосон журмын дагуу банкинд гүйлгээний харилцах данс нээх, эрх хэмжээний дотор тусгаал, заавар гаргах ажилчин, албан хаагчдыг ажилд авах ажлаас халах, шагнаж урамшуулах, хөдөлмөрийн сахилга батын арга хэмжээ ноогдуулах.